



# ЦАГААННУУР ТОСГОНЫ ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас: 70422954  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур  
Утас: 94159291  
Цахим хаяг:  
ainurmarkhava@yahoo.com

**Хаяг:** Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар  
**Цахим хуудас:** www.audit.mn

**2018 оны 3 дугаар сар**

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /БӨА-2018/01/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 08-наас 3 дугаар сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөж, ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 3 дугаар сарын 05-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 14-нээс 3 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 19-нд Цагааннуур тосгоны захирагчид гардуулна.

### **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Цагааннуур тосгоны захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны

тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

“Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулна” гэж Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Цагааннуур тосгоны захирагч нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Цагааннуур тосгоны захирагчийн 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай

илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 41-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Прибаланс” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Тав. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 27 буюу “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн

гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

## 6.1 Орлого, татаас санхүүжилтийн талаар

### 6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 874,6 сая төгрөгийн санхүүжилт, 1,1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

### 6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 105,6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 9,4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. ОНХ сангаас 14,2 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, үйл ажиллагааны орлогоос 0,6 сая төгрөгийг оруулсан байна.

### 6.1.3 Өөрийн орлого

Цагааннуур тосгоны төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 0,6 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 0,6 сая төгрөгийн орлого оруулсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар СХСангийн эргэн төлөлтөөс орсон 2,5 сая төгрөгийн, ЭЭС-аас орсон 8,5 сая төгрөгийн орлогыг өөрийн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна.

### 6.1.4 Татварын орлого

Аймгийн ИТХ-аас Цагааннуур тосгоны 2017 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 5,5 сая төгрөгөөр баталжээ. Орлогын 62,6 хувийг ХАОАТатвараас, 36,5 хувийг бусад татвараас, 0,9 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №01		/сая төгрөг/			
	ᠶᠡᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>А.Урсгал орлого</b>	5,5	10,1	4,6	1,82
2	<b>Татварын орлого</b>	5,5	9,4	3,9	1,71
3	<b>ХАОАТатвар</b>	3,5	7,7	4,2	2,2
4	<b>Өмчийн татвар</b>	0,00	0,00		0,0
5	<b>Бусад татвар</b>	2,0	1,7	-0,3	85,7
6	<b>II.Татварын бус орлого</b>	0,0	0,6	0,6	-
7	<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	0,05	0,01	0,04	0,2

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 10,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 4,5 сая төгрөгөөр буюу 1,8 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийт орлогын 62,6 хувийг ХАОАТатварын, 36,5 хувийг бусад татварын, 0,9 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 4,2 сая төгрөгөөр буюу 221,5 хувиар давж, татварын бус орлого 0,7 сая төгрөг буюу 100 хувиар давж биелэгджээ.

Бусад татвар 0,3 сая төгрөг буюу 14,3 хувиар, хөрөнгийн орлого 40,0 мянган төгрөг буюу 80,0 хувиар тасарчээ.

Орон нутгийн орлогын 910 тоот дансны оны эхэнд үлдэгдэл 1,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 10,1 сая төгрөгийн татварын орлого оруулж, 7,1 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

### **6.1.5 Бусад**

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 14.2 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 2,5 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан 8,5 сая төгрөгийн орлого оруулсан байна. Урьд жилд сургуулиас татан төвлөрүүлсэн 1,4 сая төгрөгийг зарцуулаагүй, бусад төсөвт байгууллагуудаас татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна.

## **6.2 Зарлага санхүүжилтийн талаар**

### **6.2.1 Санхүүжилтийн зарцуулалт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цагааннуур тосгоны ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 1004,5 сая төгрөгийн төсөв батлагдсаны 874,6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 114.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14.2 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 0,7 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 874,6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 114.9 сая төгрөгийн, аймгийн ОНХСангаас орлогоос 3.3 сая төгрөгийн, үйл ажиллагааны орлогоос 0,7 сая төгрөгийн орлого оруулж, бүгд 993,6 зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 10,9 сая

төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь ОНХСан 10,9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

Хүснэгт №02		/ сая төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>1</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	1004,5	993,6	98,9 %	10,9
<b>1.1</b>	<b>Урсгал зардал</b>	1004,5	993,6	98,9 %	10,9
<b>1.2</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	0	0	0.0%	0.0
<b>2</b>	<b>Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр</b>	1004,5	993,6	98,9 %	10,9
<b>2.1</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/</b>	874,6	874,6	100 %	-
<b>2.2</b>	<b>Орон нутгийн төсвөөс</b>	114,9	114,9	100 %	-
<b>2.3</b>	<b>Орон нутгийн хөгжлийн сангаас</b>	14,2	3,3	23,2%	10,9
<b>2.4</b>	<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос</b>	0,6	0,6	100%	-

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал, эд хогшил урсгал засварын зардал, урсгал шилжүүлгийн зардлыг төсөвтөө багтаан зарцуулж, байр ашиглалттай холбоотой зардал, бараа үйлчилгээний зардал, хөрөнгийн зардлыг 1,5-10,9 сая төгрөгөөр хэмнэж, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 0,5-2,3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт №03		/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувиар	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,004,5	993,6	(10,90)	98.92	
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	990,3	990,3	-	100.00	
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	894,6	894,6	-	100.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,9	665,9	-	100.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,1	73,1	-	100.00	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,1	42,1	-	100.00	
Хангамж, бараа материалын зардал	20,1	20,1	-	100.00	
Нормативт зардал	60,3	60,3	-	100.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	3,5	3,5	-	100.00	
Томилолт, зочны зардал	4,3	4,3	0,04		



				100.94
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,8	20,8	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,5	4,5	(0,04)	99.11
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,6	95,6	-	100.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>14,2</b>	<b>3,3</b>	(10,9)	23.2
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,004,5	993,6	(10,9)	98.92
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	874,6	874,6	-	100.00
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,2	3,3	(10,9)	23.36
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	114,9	114,9	-	100.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0, 6	0, 6	-	100.00

*Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:*

Хүснэгт №04 /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Тосгоны захирагч	<b>114,9</b>	<b>114,9</b>	<b>0.0</b>	100.0
Бүрэн дунд сургууль	<b>397,7</b>	<b>397,7</b>	<b>0.0</b>	100.0
Хүүхдийн цэцэрлэг	<b>194,0</b>	<b>194,0</b>	<b>0.0</b>	100.0
ЭМтөв	<b>232,8</b>	<b>232,8</b>	<b>0.0</b>	100.0
Соёлын төв	<b>50,7</b>	<b>50,7</b>	<b>0.0</b>	100.0
ОНХ сан	<b>14,2</b>	<b>3,3</b>	<b>-10,9</b>	23.4
<b>Бүгд</b>	<b>1,004,5</b>	<b>993,6</b>	<b>-10,9</b>	<b>98.9</b>

Төсөвт байгууллагууд төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулж, ОНХ сангийн үлдэгдэл 10,9 сая төгрөг байж, төлөвлөсөн дүнгээс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

### **6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт**

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 1,1 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

### **6.2.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт**

Цагааннуур тосгоны 5 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр батлагдсан төсвийн дагуу 874,6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

#### 6.2.4 Сангийн зарцуулалт

Цагааннуур тосгоны ОНХСан нь оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй ба тайлант онд 14,2 сая төгрөгийн санхүүжилт авч, 3,3 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 10,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 2,5 сая төгрөгийн орлогыг оруулсан байна. Зээлийн эргэн төлөлтөөс зээл олгоогүй ба оны эцэст 3,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.СХСан нь жилийн эцэст 1,4 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа 18,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 8,5 сая төгрөгийн орлого оруулж, 8,5 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 26,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

#### 6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №05		/сая төгрөгөөр/		
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,7	20,0	16,4
311	Кассанд байгаа бэлэн мөнгө			
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,7	20,0	16,4
3121	<b>Төгрөг</b>			
31211	Төрийн сангийн харилцах	3,7	20,0	16,4
31212	Монгол банкин дахь харилцах			
31213	Арилжааны банк дахь харилцах	0,02	0,03	0,01

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 20,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,03 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 20,0 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Үүнд:ОНХСангийн үлдэгдэл 10,9 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 3,3 сая төгрөг, Орон нутгийн орлогын данс үлдэгдэл 4,4 сая төгрөг, сургуулиас урьд жилд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө 1,4 сая төгрөг байна.

Арилжаны банкинд байгаа 26,4 мянган төгрөг нь эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл байна.

### 6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

Хүснэгт №06

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>11,4</b>	<b>1,4</b>	<b>-9,9</b>
3351	Ажиллагчидтай холбогдсон авлага	0,08		-0,08
3352	Төлбөртэй үйлчилгээний авлага			
	Татаас, санхүүжилтийн авлага	<b>7,3</b>		<b>-7,3</b>
	<b>Бусад авлага</b>	<b>3,9</b>	<b>1,4</b>	<b>-2,5</b>
	Байгууллагаас авах авлага			
	Хувь хүмүүсээс авах авлага	<b>3,9</b>	<b>1,4</b>	<b>-2,5</b>

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 9,9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Сум хөгжүүлэх сангийн авлага 2,5 сая төгрөгөөр, ОНХСангийн авлага 7,3 сая төгрөгөөр буурсан байна.

### 6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

Хүснэгт №07

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>62,7</b>	<b>63,7</b>	<b>1,0</b>
351	Түүхий эд материал	14,8	20,9	6,1
354	Хангамжийн материал	47,9	42,8	-5,1

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 1,0 сая төгрөгөөр өссөн байна. Түүхий эд материал 6,2 сая төгрөгөөр нэмэгдэж, хангамжийн материал 5,1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 4,9 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

### 6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №08

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1 069,8</b>	<b>1 013,3</b>	<b>-56,5</b>
391	Газар			
392	Биет хөрөнгө	<b>1 069,3</b>	<b>1 012,9</b>	<b>-56,4</b>
393	Биет бус хөрөнгө	<b>0,5</b>	<b>0,3</b>	<b>-0,2</b>

Үндсэн хөрөнгө оны эхнээс 56,5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 0,4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 32,2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. 49,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 76,1 сая төгрөгийн элэгдэл тооцож, 38,7 сая төгрөгийн элэгдлийг хасах бичилт хийж, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 1656,0 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 29,9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас Дунд сургууль нь 20,8 сая төгрөгийн, ЭМТөв 0,9 сая төгрөгийн, хүүхдийн цэцэрлэг 8,4 сая төгрөгийн, Соёлын төв 1,0 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан нь 1,3 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авчээ. Тайлант онд нийтдээ 51,7 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассаны 49,4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 2,3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

### 6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №09		/сая төгрөгөөр/		
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,7	15,2	8,5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,7	15,2	8,5
413	Өглөг	0,00	7,8	7,8
	Ажилчидтай холбогдсон өглөг			
	Бараа үйлчилгээний зардлын өглөг			
4136	Бусад өглөг	6,7	7,3	0,6
	Байгууллагад төлөх өглөг	6,5	7,3	0,8
	Хувь хүмүүст төлөх өглөг	0,2		-0,2

Оны эхэнд 6,7 сая төгрөгийн өглөгтэй ба оны эцэст 15,2 сая төгрөг болж, үлдэгдэл 8,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсөвт байгууллагуудын өглөг 7,8 сая төгрөг, ОНХСангийн өглөг 6,2 сая төгрөг, ЭЭСангийн өглөг 1,2 сая төгрөг байна.

### 6.3.6 Цэвэр хөрөнгө/ өмчийн талаар

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 57,5 сая төгрөгөөр буурч 1083,4 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 1378,8 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 513,5 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн -808,9 сая төгрөг байна.

Тайлант онд -57,5 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн энэ хэмжээгээр нэмэгдсэн байна.

### Долоо. Шилэн дансны мэдээлэл

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

## **Найм. Аудитын дүнгийн талаар**

### **8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлд 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 41 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

### **8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орон нутгийн орлого, орлогын ерөнхий данс, санхүүжилт орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### **8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна. Үүнд:

1. Өнгөрсөн оны санхүүгийн тайланг е-тайланд аудит хийгдсэн тайлантай тохируулж засаагүйгээс зарим байгууллагын санхүүгийн тайланд эхний үлдэгдэл, орлого, зарлагын дүн зөрүүтэй байна.

Төсөвт байгууллагуудын тайлант оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг При баланс болон е-тайлан программ дахь санхүүгийн тайлантай нэгбүрчлэн тулгаж, алдаа зөрүүг арилгаж, Төвлөрүүлэн захирагчийн аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэлээ.

Шийдвэрлэсэн: Энэхүү алдааг цаашид давтан гаргахгүй байхыг асуудлын бүртгэлд тэмдэглэж анхааруулав.

### **8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Байхгүй.

### **8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Байхгүй.

### **8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Байхгүй.

### **8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав. /ТАБ-СТА-В-4/

### **8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгсөн ба биелэлтийг Цагааннуур тосгоны захирагчийн 2017 оны 6 сарын 29-ны өдрийн №129 дугаар албан бичгээр ирүүлсэн.Аудитын явцад зөвлөмжийн биелэлтийг дахин нягтлан шалгасан болно.

### **8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар**

Цагааннуур тосгоны Дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ТТЗ-ийн СНТайланд бие даасан дүгнэлт гаргаж, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Захирагчийн алба, ОНХСан, СХСан, ЭЭСангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Хүснэгт №09

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс				
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн
Тосгоны захирагч	2,2	1				1	
Дунд сургууль	1,9	1	1				
Хүүхдийн цэцэрлэг		1	1				
ЭМТөв		1	1				
Соёлын төв		1					1
ТТЗ-ийн СНТайлан		1	1				
<b>Дүн</b>	<b>4,1</b>	<b>6</b>	<b>4</b>			<b>1</b>	<b>1</b>

Цагааннуур тосгоны төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 4,1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, залруулга хийгдсэн

Захирагчийн албанд журам зөрчиж олгосон 486,0 мянган төгрөгийн урамшуулалын мөнгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

#### **8.10. Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.ХУАНГАН  
ОГНОО:2018.03.20  
Х.ЖЕНИСБЕК  
ОГНОО:2018.03.20

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР ОГНОО:2018.03.20